

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
2019 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЭЛ

1.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

/ТЗУХ-ЫН ГАДААД ХАРИЛЦАА, ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР/

1. “Албан паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ын дагуу эрх бүхий 2 албан тушаалтанд дипломат паспорт олгох хүсэлт болон холбогдох материалыг хүргүүлж ажилласан.
2. Бүгд найрамдах Энэтхэг Улсын Индор хот дахь Энэтхэгийн Удирдлагын институтад 2020 оны 01 дүгээр сарын 06-10-ны өдрүүдэд “Орон нутгийн засаг захиргааны менежементийг хөгжүүлэх нь” сэдэвт сургалтад хамрагдах албан тушаалтны холбогдох материал бүртгэлийг хийж мэдээллийг хүргүүлсэн.
3. Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлагдсантай холбогдуулан чиг үүрэг өөрчлөгдсөний дагуу байгууллагын дотоод 2 ажил арга хэмжээг зохион байгуулсан.
4. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны холбогдох 4 заалт, харъяалал бүхий 1 дэд хөтөлбөр, аймгийн эднийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, холбогдох тогтоол шийдвэрийн оны эцсийн хэрэгжилтүүдийг тооцож гаргасан байна.
5. Байгууллагын 2019 оны тооллогын арга хэмжээг зохион байгуулсан.

/СУМ, ОРОН НУТГИЙН АСУУДАЛ/

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг ИТХ-д танилцуулж 88,6 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэгдлээ. 12 сарын 18-нд аймгийн Засаг дарга Даланзадгад сумын нийт иргэдэд 2016-2019 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын тайлан болон “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хийгдсэн ажлын талаар тайлангаа тавьж танилцууллаа. Сум, багийн 2019 оны тайланг авч нэгтгэн ажиллаж байна.

/ӨРГӨДӨЛ ГОМДОЛ/

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүлээн авч холбогдох хэлтэс нэгжүүдээр дүгнүүлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүлээлгэн өгсөн байна.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 569 өргөдөл иргэдээс хүлээн авсан бөгөөд эдгээрээс хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж хариу өгсөн 548, хугацаандаа яваа 21 өргөдөл, хүсэлт байна. Аймгийн Цагдаагийн газар, Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Говь гурван сайхны сав газрын захиргаа зэрэг байууллагын албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх талаар сургалт, дадлага ажил хийж гүйцэтгэлээ.

/ХҮНИЙ НӨӨЦ/

1. Төрийн дээд шагналаар шагнуулахаар ирүүлсэн 12 иргэний материалыг аймгийн ИТХ-д уламжилсан аймгийн Засаг даргын шагналаар шагнуулахаар ирүүлсэн иргэний материалыг хянаж, аймгийн Тэргүүний ажилтан шагналаар 173 иргэн, “Жуух бичиг”-ээр 133 иргэн шагнах шийдвэрийг гаргуулж сум байгууллагуудад хүргүүлсэн. Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдож Төрийн албаны зөвлөлөөс баталж гаргасан журмуудыг сум байгууллагуудад цахимаар танилцууллаа.
2. Төрийн албаны ерөнхий шалгалтын бэлтгэл хангах мэдээлэл суртчилгааг аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн цахим хуудасд байршуулж ажиллаа. Засгийн газрын тогтоолын 38, хуралдааны тэмдэглэлийн 11, албан даалгаварын 11, захирамжийн 1, аймгийн ИТХ-ын тогтоолын 4 Зөвлөмжийн 2 бүгд 67 заалт, 2 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хугцаанд нь тайлагнасан.
3. Төрийн албан хаагчийн Хүний нөөцийн цахим сангийн шинэчлэл хийх талаар 4 байгууллагад шинээр эрх олгуулж тайланг бүрэн оруулсан, бусад байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.
4. Төрийн албаны зөвлөлд Сул орон тооны судалгаа, нөөцийн судалгаа, Удирдлагын академид мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах албан хаагчийн судалгааг гаргаж хүргүүлсэн байна.

2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС

1. Хилийн 0131 дүгээр ангид алба хааж буй 100 эмэгтэй албан хаагчдад “Эмэгтэйчүүдийн нэгдсэн зөвлөгөө”-нийг 2019 оны 12 сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулсан.
2. Аймгийн Цагдаагийн газар, Өглөөний клубб ТББ хамтран 2019-12 сарын “Архигүй баяр-Архигүй шинэ жил” болгон сарын аяныг зарлан ажиллаж байна.
3. Хууль бус эзэмшлийн газрыг цуцалсан маргаанд хариуцагчийг төлөөлөн ажиллаж байна.
4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Архидан, согтуурах, мансуурах, донтолтоос урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг зохион байгуулж байгаа Баяндалай, Манлай, Баян-овоо сумдыг шагнаж урамшуулсан байна.
5. Даланзадгад-Цогт-овоо сум хоорондын хатуу хучилттай автозам дээр авто осол ихээр гардаг “хар цэг” дээр суварга босгох арга хэмжээг зохион байгуулж, автозам дагуу 600 тэмээний хүзүүнд гэрэл ойлгогчтой тууз зүүж, зам тээврийн осол аваар гарахаас урьдчилан сэргийлсэн байна.
6. Даланзадгад сумаас Ханхонгор сумын автозам дагуу анхааруулах 5 тэмдэг тэмдэглэгээг аймгийн ГХУСАЗЗөвлөлтэй хамтран байршуулсан.
7. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулж, сургалтад 88 байгууллагын 92 албан хаагч хамрагдсан байна.
8. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 12 сард 3 байгууллагын 50 албан хаагчдад Зөрчлийн тухай хууль, Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтууд зохион байгуулсан.

9. Аймгийн Цагдаагийн газартай хамтран “Ойлгоё хүндэлье” өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулан, уг өдөрлөгт Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба, Даланзадгадын Дулааны Цахилгаан станц, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажилтан, алба хаагчдыг хамруулан, “Жендэрийн талаарх ойлголт” сэдвээр сургалт мэдээлэл хийж, “Минами” клубын сурагчдын бэлтгэсэн гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаархи “Сүүдэр ший”-г үзүүлэн, “Харилцаа хандлага” тоглоом тоглуулан, “Цагаан тууз” зүүж ажилласан. Арга хэмжээнд нийт 60 гаруй иргэд хамрагдсан байна.

3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС

/Газрын харилцаа, хот байгуулалт/

1. Аймгийн Засаг даргын захирамжаар 1102 иргэний газрын өмчлөлтэй холбоотой шийдвэр гаргасан.
2. Аймгийн Засаг даргын 11 захирамжаар иргэн, хуулийн этгээдэд газрыг шинээр буюу шинэчлэн эзэмшүүлсэн.
3. “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хүрээнд 15 сумын төвийн болон хот тосгон бусад суурины газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг боловсруулж холбогдох байгууллагаар батлуулав.
4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлийн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хүрээнд нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулав.
5. Цогтцэций сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, төсөв боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөв.

/Уул уурхай, Эрчим хүч/

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 сарын 18-ны ээлжит хурлаар Цагаан дэл уул-Өлзий боомтын асуудлыг судалж, дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайланг бэлтгэж хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан.
2. Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн ээлжит хуралдаанаар хэлэлцэгдэх салбарын үндсэн чиглэлийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, илтгэл мэдээлэл, 2020 онд салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ болон төсвийн жагсаалтыг гаргаж 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлэн баталгаажуулсан.
3. 2019.12.01-12.26-ыг хүртэлх хугацаанд Ажлын хэсэг байгуулах тухай-6, Гүйцэтгэлийн санхүүжилт олгох тухай-2, байнгын байршил тогтоох тухай-1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай-2 нийт 11 захирамжийн төсөл боловсруулан албажуулсан, цаг үеийн холбогдолтой 22 албан бичиг төлөвлөн гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.
4. Салбар чиглэлийн Төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамжийн хэрэгжилт, Засаг даргын албан даалгавар зэрэг 87 хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргасан.

5. Түгээмэл тархацтай ашигт малтмалын 3 компанийн уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж, хяналаа.

/Байгаль орчин, аялал жуулчлал/

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах 2019 оны гэрээний хэрэгжилт 93,6 хувийн гүйцэтгэлтэйгээр гаргаж, аймгийн Засаг даргын 2019.12.03-ны өдрийн 1-2983 дугаар албан тоотоор, мөн 2020 онд байгуулах гэрээний саналыг аймгийн Засаг даргын 2019.12.23-ний өдрийн 1-3215 дугаар албан тоотоор хүргүүлээд байна.
2. 2019.12.04-ний өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн 9 дүгээр Хуралдаанаар Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Монгол гэр” ажиллуулах журмыг шинэчлэн батлуулах асуудлыг хэлэлцүүлэн 9/11 дүгээр тогтоолоор батлуулж, холбогдох материалыг Хууль зүйн яам руу хүргүүлж, эрх зүйн актад бүртгүүлэх шатандаа явагдаж байна.
3. Хог хаягдлын тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан аймгийн ИТХ-ын бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 9.1.3, 9.1.4 дахь заалт “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”, “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф баталж” мөрдүүлэх гэж заасны дагуу 2019.12.04-ний өдрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлэн 9/8, 9/9 дугаар тогтоолоор тус тус батлуулж, холбогдох материалыг Хууль зүйн яам руу хүргүүлж, эрх зүйн актад бүртгүүлэх шатандаа явагдаж байна.
4. Хог хаягдлын тухай хуулийн 9.3 дахь хэсэгт заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 9.3.2, 9.3.12 дахь заалт “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”, “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баталж мөрдүүлэх гэж заасны дагуу 2019.11.29-ний өдрийн аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн Засаг даргын 2019 оны А/1354, А/1376 дугаар захирамжаар тус тус батлуулан сумдын Засаг дарга нарт чиглэл хүргүүлээд байна.
5. Сэврэй сумын нутаг Хонгорын гол, Гурвантэс сумын нутаг Хэрмэн цав зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг “Теем смайл” ХХК-тай гэрээ байгуулан 09-11 сард гүйцэтгүүлээд байна. Уг ажлын гүйцэтгэлийг Тамгын газрын даргын 2019.12.19-ний өдрийн А/324 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авч акт үйлдэж санхүүжилт 44,4 сая төгрөгийг бүрэн олгосон байна.
6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуй нэгжид урамшуулал олгох тухай” журмын дагуу 2017, 2018, 2019 онд гэрээ байгуулан мод тарьж ургуулсан 10 сумын 62 иргэн 17221 ширхэг мод тарьж ургуулсны урамшуулал 25848300 төгрөгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/1327 дугаар захирамжаар бүрэн олгосон байна.

/Зам тээвэр, барилга, хот байгуулалт/

1. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговрыг Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-д 12 дугаар сарын захирамжийг гарган СТСХ-т хүргүүлсэн. Мөн Зөнгийн түшээ ХХК-ийн нөхөн олговрыг тус зардлаас шийдвэрлэн, захирамжийг СТСХ-т хүргүүлсэн. Авто тээврийн төв, Даланзадгад

- зорчигт тээвэр ОНӨААТҮГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хүлээн авч, хээрэгжлтийг холбогдох газрын хэрэгжилтэд оруулан тооцов.
2. Барилгын тухай хууль, холбогдох журмын дагуу улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүлээн авч 15 аж ахуйн нэгж байгууллага, иргэний хүсэлтийн дагуу улсын комисс ажиллах захирамжийг гарган ГХБХБГ-т хүргүүлэв.
 3. Журмын дагуу барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст захиалагчийн төлөөллийг хэрэгжүүлэн ажиллаж, Татварын хэлтсийн барилга, Баяндалай сумын спорт заал, Соёл, спортын төвийн барилга, Даланзадгад-Баяндалай чиглэлийн 10км хатуу хучилттай авто зам зэрэг барилга, байгууламжийн гүйцэтгэлийг шалган, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.
 4. Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах чиглэлээр 6 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу ажил гүйцэтгэх гэрээний хугацааг сунгах ажлыг зохион байгуулав.
 5. ЗГҮАХ-ийн 2019 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Аймгийн дэд хөтөлбөр /удирдамжид заасан 16 дэд хөтөлбөр/-ийн хэрэгжилтийг ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын 5-р хавсралт хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлэх, аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-д хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтүүдийг тус тус боловсруулан гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.
 6. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган, шинээр барилгажуулах төслийн хүрээнд баригдаж буй 9 дүгээр орон сууцны төслийг хэрэгжүүлэгч “Гурван бухат” ХХК-д өгөх орон сууцны төлбөрөөс 2.58 кв.м буюу 3 663 600 төгрөгийг хасч тооцуулах тухай хүсэлт ирсний дагуу судлан үзэж, тус орон сууцны дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуучин барилгын буулгалтын зардал, гадна инженерийн шугам сүлжээний зардал, барилгын зураг, төсвийн зардал зэргийг шийдвэрлэсэн ба хуучин барилгын талбайн хэмжээг дахин хэмжүүлэх шаардлага тавиагүй тул гүйцэтгэгч компанид дээрх асуудлыг уламжлах талаар албан бичгээр хариу хүргүүлж ажиллалаа.
 7. Гүйцэтгэлийн баталгаа чөлөөлөх, санхүүжилт хүссэн, болон зохион байгуулалтын шинжтэй, тодорхойлолт хүргүүлэх гэх мэт 12 хариутай албан бичгийг шийдвэрлэсэн.
 8. Дахин төлөвлөлтийн 3 орон сууц, Соёл, спортын цогцолборын барилга, Музей, Театрын барилгуудад явцын хяналтыг тогтмол хийж ГХБХБГ-ын захиалагчийн хяналтын талаарх мэдээллийг тогтмол авч, баталгаажсан гүйцэтгэлийн санхүүжилтэд хяналт тавин ажиллаж байна.

/Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл/

1. Монгол улс атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойг орон нутгийн газар тариалан эрхлэгч 90 хүнийг хамруулан 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Даланзадгад суманд зохион байгууллаа.

2. 2019 оны жилийн эцсийн “Мал, тэжээвэр амьтаны тооллого”-ыг орон нутагт 12 дугаар сарын 07-17-ны өдрүүдэд зохион байгуулж ажилласан ба урьдчилсан байдлаар Өмнөговь аймаг 2019 оны жилийн эцэст 5 төрлийн малыг 15 сум өсгөж 3.0 сая толгой мал тоолуулсан дүнтэй байна.
3. Өмнөговь аймгийн хэмжээнд 2019 оныг “Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил”, салбарын хувьд “Соёлыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Малчдын урлагийн наадам”-ыг 2019 оны 12 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Даланзадгад суманд зохион байгуулсан. Тус наадамд 15 сумын 100 гаруй авъяастнууд 5 төрлөөр өрсөлдөж, төрөд бүрээс эхний 3 байрыг шалгаруулж, нийлбэр дүнгээр сумдыг шалгаруулж ажилласан ба тус наадмаар телевизийн бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэж олон нийтийн телевизүүдээр цувралаар гаргаж байна.
4. “Хөдөө аж ахуй үйлдвэржилтийн жил-2019”-ийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн, зохион байгуулсан ажлын тайлангаа Даланзадгад суманд 12 дугаар сарын 18-ны өдөр нийт иргэдэд тайлагнж ажиллав.
5. Мөн Өмнөговь аймгийн хэмжээнд 2019 оныг “Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил” болгон зарлаж, жилийн хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлсэн ажлын тайлангаар нэвтрүүлэг бэлтгэж, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх ажлыг зохион байгуулсан.

/Эдийн засаг, хөрөнгө оруулалт, төлөвлөлт/

1. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны Үндсэн чиглэлд нийт 134 зорилт, арга хэмжээ тусгагдаж, нийт 159,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгдснөөс Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 25,7 тэрбум, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 99,96 тэрбум, төсөл хөтөлбөрөөр 33,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, гүйцэтгэж ажиллалаа. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тооцон гаргаж, аймгийн ИТХ-ын 2019 оны 12 сарын 04-ний ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн, 95,2 хувийн биелэлттэйгээр дүгнүүлэв.
2. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны Үндсэн чиглэлд нийт 138 зорилт, арга хэмжээ төлөвлөгдөж, нийт 166,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгагдан аймгийн ИТХ ИТХ-ын 2019 оны 12 сарын 04-ний ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. 2020 оны Үндсэн чиглэлийн хүрээнд Нийгмийн салбарт 68,9 тэрбум, Эдийн засгийн салбарт 24,8 тэрбум, Дэд бүтцийн салбарт 63,0 тэрбум, Төрийн захиргаа, хууль, батлан хамгаалах чиглэлээр 9,4 тэрбум төгрөгийн ажлуудыг хэрэгжүүлэхээр батлагдсан байна. 2020 онд улсын төсвөөс 26,4 тэрбум, орон нутгийн төсвөөс 117,8 тэрбум, төсвөөс бусад эх үүсвэртэй төсөл хөтөлбөрөөр 21,9 тэрбум төгрөг төлөвлөгдсөн байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд аймагт нийт 18842,9 сая төгрөгийн 28 ажил эрх шилжиж ирсэн бөгөөд 2019 оны 12 сарын 01-ний байдлаар энэ онд хийгдэх ажил 95,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийн мэдээллийг холбогдох яамдад тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. 2019 онд эрх шилжиж ирсэн ажлуудаас Улсын 2020 оны төсвийн

тухай хуулиар батлагдсны дагуу 10 ажил 2020 онд он дамжин хэрэгжих бөгөөд 2019 онд батлагдсан төсөвт санхүүжилтийн дагуу ажлыг зохион байгуулан гүйцэтгэж ажиллав.

4. Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу 2019 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг СЯ-нд гарган хүргүүлж, шаардлагатай ажлуудын санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгаа гарган авах, дууссан ажлуудыг гүйцэтгэлийг СЯ-нд хүргүүлэх ажлуудыг зохион байгууллаа.
5. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны Үндсэн чиглэл, 2020 оны төсвийг үндэслэн холбогдох хуулийн дагуу 2020 онд худалдан авах шаардлагатай нийт 102,4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 254 төслийн жагсаалтыг гарган ажиллалаа.
6. ҮХГазраас Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн төсөл, ҮХГазар, Өмнөговь аймаг, МУИС-ийн хамтарсан гэрээний дагуу МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгээс нийт 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Өмнийн говийн бүсийн хөгжлийн хөтөлбөр"-ийн төслийг тус тус боловсруулан бэлэн болгосон. Орон нутгийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр-2030 бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, зөвлөх багийг шалгаруулахаар тендерийг зарлаад байна.
7. Аймгийн хэмжээнд мөрдөж ажиллах "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" аймгийн ИТХ-ын 2018 оны 6/6 дугаар тогтоолыг сумдад болон Татварын хэлтэс хүргүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, хяналт тавин ажиллаж байна. 2019 онд нийт 80 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгаж, аж ахуйн нэгжүүдээс тусгай зөвшөөрөл шинээр авах 22 хүсэлт ирснээс 18 тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 4 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бөгөөд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, энэхүү тогтоолыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгжүүдээс улсын тэмдэгтийн хураамж болох нийт 22,5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.
8. Хариуцсан салбар, чиглэлийн дагуу тогтоол, шийдвэр, хөтөлбөр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг цаг хугацаанд нь гаргаж ажиллав.

4. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС

/Боловсрол/

1. Манлай сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгыг хүлээн авч байнгын ашиглалтад орууллаа. Тус ажлыг "Вентана констракшн" ХХК "Говийн оюу хөгжлийг дэмжих" сангийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн болно. Мөн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж, "Элбэг туулай" ХХК "Говийн оюу хөгжлийг дэмжих" сангийн 178.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гэрээ байгуулан гүйцэтгэж, тоног төхөөрөмжөөр 100 хувь ханган, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүллээ.
2. Хүрмэн сумын 50 хүүхдийн дотуур байрны барилгыг хүлээн авч байнгын ашиглалтад оруулж, хүүхдийн амьдрах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүллээ.

Тус ажлыг “Оршдос” ХХК улсын төсвийн 885.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн болно.

3. МУБИС, Глобал удирдагч дээд сургуультай Хамтран ажиллах гэрээ байгуулж, боловсрол, эрүүл мэндийн салбарын багш, эмч, мэргэжилтнүүд болох 240 хүнийг магистрын сургалтад элсүүлэн, сургалтын төлбөрийг орон нутгаас дэмжиж, нийт 240,0 сая төгрөгийг зарцууллаа.

/Эрүүл мэнд/

1. Ухаалаг утас ашиглан Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тасаг, кабинетийн эмчид үзүүлэх дараалал захиалах үйлчилгээг нэвтрүүлэхээр мобайл апплекишн боловсруулж дууссан. 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс эрүүл мэндийн салбарын үйлчилгээнд нэвтрүүлнэ.
2. "Элэг бүтэн Өмнөговьчууд" хөтөлбөрийн хүрээнд В, С вирустай хүмүүсийн вирусийн идэвхжилийг тоолох үйлчилгээг улсын хэмжээнд анх удаа орон нутагт нэвтрүүлж Бүсийн оношилгоо эмчилгээний төв дээр нийт 10 хүний идэвхжилийг тоолсон. Вирусийн идэвхжилтийг тоолоход шаардлагатай эм урвалж, тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 18,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хангаад байна.
3. Аймгийн хэмжээнд Томуу, томуу төст өвчний тархалт нэмэгдэх хандлагатай байгаа тул өвчний тархалтыг бууруулах, халдварлах эрсдэлийг багасгах зорилгоор сайн дурын дархлаажуулалтын арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж 1600 иргэнийг хамруулаад байн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зардлаар 0-5 хүртлэх насны хүүхдийг үнэ төлбөргүй сайн дурын дархлаажуулалтын арга хэмжээнд хамруулсан.

/Нийгэм хамгаалал/

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Ээлтэй нийгмийн төлөө” арга хэмжээг зохион байгууллаа.
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгаа арга хэмжээг Даланзадгад, Цогтцэций суманд зохион байгуулж, нийт 960 хөгжлийн бэрхшээлтэй, хоол тэжээлийн дутагдалтай 60 хүүхэд, 60 эцэг эх хамрагдлаа.
 - Үйлчилгээний байгууллагуудын албан хаагчдад Дохионы хэлний сургалтыг зохион байгуулж 20 гаруй албан хаагчид хамрагдлаа.
 - Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэмжих төсөлд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үзэсгэлэн зохион байгуулж 4 сумын 10 гаруй иргэд оролцлоо.
 - “Ээлтэй нийгмийн төлөө” баярын хурлыг 15 сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл 150 гаруй иргэдийг хамруулан зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн тоглолтыг зохион байгууллаа.
2. Хүүхдийн сүлд модны “Харшийн сүлд мод” арга хэмжээг зохион байгуулан шилдэг хүүхдийг шалгаруулан урамшуулж, арга хэмжээнд оролцсон 1500 гаруй хүүхдэд өвлийн өвгөний бэлгийг гардуулан өглөө.
3. Засаг даргын дэргэдэх Ахмадын зөвлөл хуралдаж 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа аймгийн удирдлагуудад тайлагнаж, 2020 онд хийх ажлын талаар ярилцлага зохион байгууллаа.

/Соёл/

1. Соёлыг дэмжих жилийн тайлан, хаалтын арга хэмжээг зохион байгуулж, шилдэг сум, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулан урамшууллаа.
2. Олон улс болон тив дэлхийн спортын уралдаан тэмцээнд амжилт гаргасан баг тамирчдыг аймгийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнаж, алдаршууллаа.

6. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

1. Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Төсвийн гүйцэтгэлийн 11-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээг татууллаа.
2. Нийт 43 төсөвт байгууллагуудын 2019 оны 11 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан.
3. Төсвийн орлогын 11-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулан хүлээн авлаа.
4. Орон нутгийн байгууллагуудын 11 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ.
5. Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 12-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
6. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 12-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
7. Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын баталгаажсан ажлын санхүүжилтийг олгож байна.
8. Аймгийн төрийн сангийн харъяа 43 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа.
9. Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрийбаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд хяналт тавин ажиллалаа.
10. Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн.
11. Нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг сум, байгууллагуудаас аван нээж ажиллалаа.
12. Төсөв санхүүгийн 11 дугаар сарын мэдээллийг нэгтгэн хэвлэж, E-оффисст мэдээлэл орууллаа.
13. 2019 оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл санхүүжилтийн тооцоо нийлж, санхүүжилтийг олгож байна.
14. 2019 оны эцсийн Төрийн сангийн хаалтыг хийж ажиллаж байна.

6. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
1	Арга хэмжээ: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтэд ХШҮ хийх, тайлан дүгнэлт боловсруулж танилцуулах	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн ХШҮ хийж тайлан дүгнэлтээ бичиж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд ХШҮ хийх ажил үргэлжилж байна-50%.	100
2	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтэд ХШҮ хийх, тайлан дүгнэлт боловсруулж танилцуулах	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтэд ХШҮ хийж тайлан, дүгнэлтийг бэлэн болгож ЗГХЭГ-т хүргүүлэхээр дахиж хянах, жилийн эцсийн мэдээ, тайлангаас нэмэлт оруулах зэрэг ажил хийгдэж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын 7 дугаар хуралдаанаар хэлэлцэж баталсан болно.	100
3	Арга хэмжээ: Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн 2019 оны хэрэгжилтэд ХШҮ хийх, тайлан дүгнэлт боловсруулж танилцуулах	Аймгийн ИТХ-ын 171 тогтоолын 2019 оны хэрэгжилтэд ХШҮ хийж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд хүргүүлээд байна. Аймгийн ИТХ-ын шийдвэрийн 2019 оны хэрэгжилт 91.3% буюу “Бүрэн хэрэгжсэн” үнэлгээтэй гарлаа	100
4	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын 2019 оны хэрэгжилтэд ХШҮ хийх, тайлан дүгнэлт боловсруулж танилцуулах	Аймгийн Засаг даргын 378 захирамж, 6 албан даалгаврын хэрэгжилтэд ХШҮ хийгдэж байна.	50
5	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргаас яамдын сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд ХШҮ хийх, тайлан дүгнэлт боловсруулж танилцуулах	БОАЖЯ, БХЯ, ХНХЯ, ЗТЯ зэрэг яамдын сайдуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд ХШҮ хийгээд байна.	100
6	Арга хэмжээ: Шинээр гарсан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэх, танилцуулах, эзэнжүүлэх ажлыг зохион байгуулах	Шинээр гарсан бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэн аймгийн удирдлага, нэгжийн дарга нарт танилцуулах, хяналтад авах, хариуцсан албан тушаалтанд хүргэх ажил тогтмол хийгдэж байна.	100
7	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, төсвийн байгуулагууд болон сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд ХШҮ хийх, тайлан дүгнэлт, зөвлөмж гаргаж хүргүүлэх	Нийт 21 агентлаг, төсвийн 5 байгууллага, 15 сумын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан, дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээд байна. Сум, агентлагт хүргэх ажил явагдаж байна.	100

8	<p>Арга хэмжээ: Хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах</p>	<p>Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх талаар мэргэжлийн байгууллагын оролцоотой нэгдсэн сургалт зохион байгуулж баруун, зүүн бүсийн сумдууд гэсэн 2 групп болгон ажиллуулж, судалгаа авах, мэдээлэл цуглуулах ажиллагаа дуусч нэгтгэх, дүгнэх ажил үргэлжилж байна</p>	80
9	<p>Арга хэмжээ: Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтнуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах</p>	<p>Сум, агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 45 ажилтнуудыг оролцуулсан “Үр дүнд суурилсан ХШҮ-г хөгжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж нийт ХШҮ-ний ажилтнуудад зориулсан уриалга гаргасан. Мөн ХШҮ-ний ажилтнуудын нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр зохион байгуулдаг хандив тусламжийн ажлаа үргэлжлүүлж 1-р цэцэрлэгийн бага бүлгийн ангид 200 орчим шагай гардуулж өгсөн.</p>	100
10	<p>Арга хэмжээ: Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, ажилтнуудын 2019 оны ажлыг дүгнэж шалгаруулах</p>	<p>Нутгийн захиргааны байгууллагын ХШҮ-ний тогтолцоог бэхжүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулахад идэвхи санаачилгатай сайн ажиллаж, нэгжийн ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, ХШҮ-ний ажлыг тогтмолжуулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Д.Бямбадэлгэр /Сэврэй сумын Засаг даргын Тамгын газрын дарга/, А.Нарандэлгэр /Цогт-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын дарга/, А.Одончимэг /Номын сангийн дарга/, Ц.Энхтуул /Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга/, У.Отгонцэцэг /Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн/, Ц.Баярмаа /Номгон сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн/ нарыг аймгийн Засаг даргын 2019 оны А/1302 дугаар захирамжаар хяналт-шинжилгээ, үнэлгээний 2019 оны шилдэг ажилтнаар өргөмжилж 250.0 мянган төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан.</p>	100
11	<p>Арга хэмжээ: Байгууллагын дотоод ажил болон нэгдсэн арга хэмжээнд оролцох</p>	<p>Байгууллагаас зохион байгуулсан Шинэ жилийн арга хэмжээнд бүрэн оролцож байгууллагын шилдэг ажилтан /В.Дэлгэрмаа/, аймгийн Засаг даргын жуух бичиг /М.Номиндарь/-ээр тус тус 1 мэргэжилтэн шалгарч, хэлтсийн хамт олон цалингийн 40%-иар шагнуулсан. Мөн тус хэлтсээс /хэлтсийн дарга/ ЗГХЭГ-ын ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоол нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллаж байна.</p>	100
12	<p>Арга хэмжээ: Байгууллагын төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх</p>	<p>“Байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг боловсруулах арга зүй” сэдвээр Хүрмэн, Даланзадгад сум, ЭМГ, ЦГ, УЦУОШТ, ГГБЦГХЗ, БСУГ, ХХҮГ зэрэг байгууллагад тэдний захиалга, хүсэлтийн дагуу сургалт зохион байгуулаад байна.</p>	100

7. ЦЭРГИЙН ШТАБ

1. “Цайдам” дохионы хадгалалт хамгаалалтыг 03, 17-ны өдрүүдэд Цэргийн штабын дарга хурандаа Ж.Амаржаргал шалгаж тэмдэглэл хөтөлсөн. Дохионы хадгалалт хамгаалалт хэвийн байна.
2. 2019 оны цэргийн бүртгэлийг аймгийн хэмжээнд зохион байгуулж эхлээд байгаа ба сумдын бүртгэл явуулж буй байдалд хяналт тавин, сумдын ЗДТГ-ын дарга нарыг заавар, зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Цэргийн бүртгэлийн шторк, зөвлөмжийг сумдад хүргүүлсэн.
3. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын төлбөрийн орлогын бүрдүүлэлт, түүний зарцуулалтын тайлан, гэрээгээр цэргийн алба хаагчдын болон ЦДА-ыг биеэр хаагчдын 2019 оны 4 дүгээр улирлын болон жилийн эцсийн мэдээ, Цэргийн штабын 2019 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан, Батлан хамгаалахын сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг гаргаж БХЯ-ны холбогдох газар, хэлтэст хүргүүлэв.
4. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаагчдын орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогын 50 хувь болох 9,8 сая төгрөгийг БХЯ-нд шилжүүлсэн.
5. Цэргийн штабын түүх, түүхчилсэн лавлагааг холбогдох журмын дагуу 2019 оны онцлох үйл явдлуудаар баяжуулах ажлыг зохион байгуулав.
6. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан ажлын 2019 оны хэрэгжилт 91.7 хувь, Батлан хамгаалахын сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт 97.5 хувь, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан ажил үйлчилгээ, аймгийн ЗДТГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан ажил үйлчилгээ бүрэн хэрэгжсэн бол Цэргийн штабын 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө 96.5 хувьтай тус тус

хэрэгжсэн байна. Түүнчлэн цэргийн штабт холбогдох 2019 оны тогтоол шийдвэр, захирамжийн хэрэгжилтийг тооцов.

7. 2018 онд байгуулсан төрийн алба хаагчийн үр дүнгийн гэрээг үнэлэхэд Цэргийн штабын дарга хурандаа Ж.Амаржаргал 96,5, тоо бүртгэлийн офицер дэд хурандаа Д.Эрдэнэбат 96, орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер хошууч Б.Бэрхгалт 97 үнэлгээтэй тус тус дүгнэгдсэн.
8. Батлан хамгаалахын сайдын 2016 оны а/88 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн штабыг шалгаж, үнэлэх журам”-ын дагуу дотооддоо штабын үйл ажиллагаа, төрийн нууц баримт бичгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт, шалгалт үнэлгээ хийж нотломжийг БХЯ-нд хүргүүлэв.
9. Аймгийн Засаг даргын Батлан хамгаалахын сайдтай 2019 онд хамтран ажиллах гэрээнд тусгах саналыг БХЯ-д хүргүүлсэн.
10. Цэргийн штабаас 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна.
11. Хуучин оны албан бичгийг хааж архивлах, шинэ оны ангилал гаргах ажлыг зохион байгуулав.

СУМ ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

БАЯН-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн:

ЗДТГазар: Сумын Засаг даргаас А Захирамж 10, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 3-ыг тус тус гаргасан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

ЗДТГазар: Сумын нийт ард иргэд, төрийн байгууллагын албан хаагч нар “АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНЭ” сургалтад хүн хамрагдлаа.

Багийн дарга нар, төрийн санч, Засаг даргын орлогч нар жилийн эцсийн мал тооллогын сургалтад хамрагдлаа.

Газрын даамал, нийгмийн халамжийн мэргэжлтнүүд өөрийн үүрэгт ажлын хүрээнд аймагт сургалтад хамрагдлаа.

ЕБДСургууль: Улаанбаатар хотоос Сэтгэл судлаач Бандицэрэн бүх ангийн сурагчдын дунд “Амьдралын үнэ цэнэ” лекц, сургалт тус сургалтад сумын нийт эцэг эх, төрийн албан хаагчид хамрагдсан.

Бүх сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын захирлууд Япон улсад туршлага судлахаар 4 хоног ажилласан.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерүүд Манжуур хотод туршлага судлахаар 3 хоног ажилласан.

Аймгийн төв номын сангаас 2 номын санч ирж, 6-8-р ангийн сурагчдын дунд ном уншлага, “Дараагийн хуудас” нэртэй үйл ажиллагааг зохион явуулсан.

Цэцэрлэг: Албан байгууллагын дарга, эрхлэгч нарын байгууллагын удирдлагуудын шуурхай хуралд хамрагдаж мэдээ мэдээлэл өгч ажиллалаа. Мөн байгууллага дээрээ багш ажилчдын дунд долоо хоног бүрийн нэг дэх өдөр дотоодын шуурхай хурлыг 18⁰⁰ цагт хийж

ажилласан. Дуу хөгжмийн багш И.Баасанжав “Хүүхдийг хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх тухай” сургалтад хамрагдсан.

Өмнөговь аймагт тогооч нарыг “Гал тогоо болон үйлчилгээний байгууллагын стандарт шаардлагыг танилцуулах сурталчилах” сургалтад хамруулж мэргэжил боловсролыг нь дээшлүүлж ажиллалаа.

Эрүүл мэндийн төв: Могой баг, Налих багийн зорилтот бүлгийн.....малчин өрхүүдээр явуулын үзлэг, гэрийн эргэлтийг хийсэн.

Хууль сурталчилах аяны хүрээнд Эрүүл мэндийн төвийн ажилчид болон тэдний гэр бүлд "Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль", "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль" сэдвээр сургалт явуулж, гар бөмбөгийн тэмцээн явууллаа.

ДОХ бэлгийн замын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх дэлхий нийтээрээ тэмцэх өдрийг сумандаа тэмдэглэн өнгөрүүллээ.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

ЗДТГазар: Сумын ИТХурлын хуралдаан амжилттай зохион байгуулагдаж сумын Засаг даргын дунд хугацааны хөтөлбөр, богино хугацааны хөтөлбөрүүдийг үнэлж дүгнэлээ.

THIESS Energy ХХК-ны хөрөнгө оруулалтаар сумынхаа 3 багийн 5 малчдын 5 гүн өрмийн худаг нарны автомат цахилгаан үүсгүүр суурилууллаа.

Сумын 25 ахмадыг Улаанбаатар хот, Төрийн ордонтой танилцуулах ажлыг зохион байгууллаа.

Соёлыг дэмжих жилийн хүрээнд сумын нутаг дэвсгэрийн хэсэгчилсэн талбайнуудад хийлгэсэн соёлын өвийн судалгаа, сумын овог аймгуудыг судлах угсаатны зүйн судалгааны ажлын тайлангуудаа Монголын түүхийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн археологи авран хамгаалах салбарын эрдэмтдийн баг суманд хүлээлгэн өглөө.

Сэтгэл судлаач, эмч илтгэгч н.Бандицэрэнг сумандаа урьж ирүүлэн “Амьдралын үнэ” лекц сургалтыг сумынхаа нийт хөдөлмөрчид, сургуулийн сурагчид, төрийн албан хаагч нартаа хийлгэлээ.

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтад тоолох тооллогын үйл ажиллагааг 3 багийн хэмжээнд 6 хэсэг байгуулагдан амжилттай зохион байгуулж сумын хэмжээнд мал сүрэг 5 төрөл дээрээ өсөж нийт 2018 оны тооллогоос хойш 26914 толгойгоор өссөн байна.

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтад тоолох явцыг хянах аймгаас томилогсдон хяналтын ажлын хэсэг Баян-Овоо сумын Могойтй Налих багт хяналтын тооллого хийлээ.

Багуудын 4-р улирлын ИНХ-аа амжилттай зохион байгуулж мөн багуудын малчдын шинэ жилийн баяраа тэмдэглэлээ.

Залуу малчид тэмээ сонирхогчдоо дэмжих зорилгоор зохион байгуулдаг “УНАГАН ТАМГАТАЙ ТОРОМ”-ны уралдаанаа зохион байгууллаа.

1,6 км Халаалт дулааны шугам шинээр байгуулах ажил үргэлжилж байна.

Нийгмийн даатгалын байцаагч: Сайн дурын даатгалын шимтгэл төлсөн 26 иргэн, Эрүүл мэндийн даатгал төлсөн 12 иргэн, Шинээр тэтгэвэр тогтоолгосон -2, Жирэмсэн амаржсаны тэтгэмж – 2, ажилгүйдлийн тэтгэмж 13 иргэнд, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын буцаан олголт 3 иргэнд нийгмийн даатгалын дэвтэр олголт -1 иргэнд тус тус үйлчилгээ үзүүлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, мал эмнэлгийн тасгийн талаар: Багийн хурлуудаар явж малчид, иргэдийн өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах талаар заавар зөвлөгөө өгч ажиллав.

БОУУХМэргэжилтэн, байгаль хамгаалагч: Баян зайсан нэртэй хайгуулын талбайд хийгдсэн байгаль орчны техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авлаа.

ЕБДСургууль: Сургуулийн урлагийн үзлэгийн наадмаа амжилттай зохион байгуулж 8 төрлөөр аваргуудаа шалгарууллаа.

Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгөөр Мэдээлэл зүйн шинэ танхимаа тохижуулж ашиглалтад хүлээн авлаа.

Цэцэрлэг: “11 сарын Манлай бөх ” шалгаруулах бөхийн барилдааныг 6-8 нас, 9-11 нас, 12-15 насны эрэгтэй сурагчдын дунд зохион явуулсан.Сэтгэл судлаач Бандицэрэн бүх ангийн сурагчдын дунд “ Амьдралын үнэ цэнэ ” лекц, сургалт тус сургалтанд сумын нийт эцэг эх, төрийн албан хаагчид хамрагдсан. Урлагийн наадмыг 2-9-р ангийн сурагчдын дунд зохион явуулж аваргуудаа шалгаруулсан.

Соёлын төв: Аймгийн хөдөө аж ахуйг дэмжих жилийн хүрээнд малчдын дунд зохион байгуулж буй “МАЛЧДЫН УРЛАГИЙН НААДАМД” сумынхаа малчдыг бэлтгэн оролцууллаа. Мөн багуудын хурал, шинэ жилээр урлаг соёлын үйлчилгээ үзүүлж ажиллаа.

БУЛГАН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

-Сургуулийн захирал 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг сумын Засаг дарга, ЗДТГазрын даргад, БСУГазрын даргад үр дүнгийн тайлангаа тус тус гаргаж үнэлүүлсэн байна. Багш, ажилчдын шуурхай хурлыг 2 удаа зохион байгуулж Манжуур хотын зарим сургуулийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалж ирсэн талаарх мэдээлэл танилцуулга хийлээ. Захирал А.Ганзориг багш нарт “Аюулгүй ажиллагаа” сэдвээр сургалт явууллаа. Сургуулийн бичиг хэргийн ажилтан Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн ажилтны хамт аймагт зохион байгуулагдсан архивчдын 2 өдрийн сургалтад хамрагдав.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт .

ЭМГ, АШУҮИС-аас зохион “Тэмбүүг устгая” сургалтанд их эмч Ц.Нармандах, лаборант нар хамрагдсан. Өмнөговь аймагт болсон тогооч нарын ур чадварын тэмцээн уралдаанд Тогооч Г.Уртнасан амжилттай оролцоод ирсэн.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

-Цэргийн нэгдсэн бүртгэл 12 сард явагдаж дууслаа.

Төсөвт байгууллагуудын 11-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээг нэгтгэн Төрийн сангийн программд шивж мэдээлэв.10-р сарын Орон нутгийн орлогыг хаалтын дансруу хааж, гүйцэтгэлийг татварын байцаагчтай тулган аймагт мэдээлэв. Аймгаас ирсэн 2019 оны 12-р сарын санхүүгийн дэмжлэгийг орлогын дансанд хааж, орон нутгийн байгууллагын санхүүжилтийг олгов. 2019 оны 11-р сарын шилэн дансны мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байршуулж, байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажиллав. Төсөвт байгууллагуудын 12-р сарын гүйлгээг хийж байна.ЗДТГ, ГБСалбарын нэмэлт санхүүжилтийн дансны эрхийг нээлгэж, бүх төсөвт байгууллагын говийн дэмжлэгийн гүйлгээг хийж олгов.Сумын ИТХурлаар 2018 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл, 2020 оны төсвийг хэлэлцэн батлуулав.

- Эрүүл мэндийн төвийн Эмчийн үзлэгт 191 хүнийг хамруулсан. Түргэн тусламжийн дуудлага 6 ирж тусламжийг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлсэн. Товлолт дархлаажуулалтын вакцинд 18 хүүхдийг хамрууллаа.Нийт 22 жирэмсэн эхийг хянаж байна. Сумын эрүүл мэндийн төвөөс эмч нар ирж хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг,цагаан хорхойн шинжилгээ авсан.

- Тухайн сард зохион байгуулсан ажил

Байгууллагуудын дунд явагддаг “Урлагийн наадам”-д боллоо.1-9 дугаар ангийн сурагчдын урлагийн үзлэг явагдаж шилдэгүүдээ тодрууллаа.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн хэрэгжилтүүд, “Оюуны хурд”, “Англи хэлтэй Өмнөговь”, “Багш хөгжил”, “Хүүхэд хөгжлийн түлхүүр” зэрэг дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг И-Оффиссоор шивж илгээв.

Дотуур байрын сурагчдын шинэ жилийн тоглолтоо сургуулийнхаа спорт зааланд нийт хүүхэд багачууд, эцэг эх, багш, ажилчдад баярын концертыг тоглосон.

Хүний нөөцийн систем рүү орж 2019 онд ажлаас чөлөөлөгдсөн хүмүүсийн хасалтыг хийж, багш, ажилчдын 2019 онд шинээр авсан гавьяа шагналыг нэмлээ. “Ном миний найз” аяны хүрээнд 3-н бүлгийн хүүхдүүд үлгэрээр жүжигчилсэн тоглолт хийсэн. Мөн 3-н бүлгийн эцэг эхчүүд үлгэр сонгож соёлын төвд жүжигчилсэн тоглолт хүүхдүүддээ тоглож үзүүлэв.

Шинэлэг ажил

2019.12.07. 08-нд Камбож улсад явагдсан 4500 хүүхэд оролцсон цээж тооллын Дэлхийн аваргын тэмцээнд оролцсон манай сургуулийн 4, 5, 6-р ангийн 3 сурагч **“АЛТАН ЦОМ”**-ын эзэн болж амжилт гаргалаа. Сургуулийн хамт олон Соёлыг дэмжих жилийн хүрээнд сурагчдын сурч хөгжих таатай орчин бүрдүүлж ажилласанд талархал илэрхийлж “Бид нийтийн соёлыг эрхэмлэдэг аймаг” аяны **“ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА”**-аар шалгарлаа.

Багт хийгдсэн ажил: Жилийн эцсийн мал тооллого 4-н багийн малчин өрх хамрагдлаа.

ГУРВАНТЭС СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 2019 оны 12 сарын 06-ны өдөр хуралдаж 5 тогтоол, сумын Засаг дарга 2 захирамж, Засаг даргын Тамгын газрын дарга А тушаал 1-ийг тус тус гаргалаа.

ХОЁР: Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан ажил

Мал эмнэлгийн тасгийн дарга Ч. Ундармаа, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн Ц. Урангуа нар аймгийн төвд болон Улаанбаатар хотод сургалтанд хамрагдсан.

Хөдөө аж ахуйн тасгийн дарга Б. Балмаа, мэргэжилтэн Ц. Урангуа нар Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Атар газар хөгжсний 60 жилийн ойд газар тариалан эрхлэгчдийн хамт оролцсон.

Гурав: Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

ГУРВАНТЭС СУМ ДӨРВӨН УЛИРЛЫН ХҮЛЭМЖТЭЙ БОЛЛОО.

Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн жилийн хүрээнд, Тус суманд үйл ажиллагаа явуулдаг “ӨСӨХ ЗООС” ХХК нь энэ онд Гурвантэс суманд 4-н улирлын хүлэмжийг барьж байгуулан ашиглалтанд өглөө. Ингэснээр сумын иргэд нь 4 улирлын турш хүнсний ногоогоо сумандаа тариалж хоол хүнсэндээ ашиглах бүрэн боломж, бололцоо нээгдсэн юм. Тус байгууламжийн нээлтийн үеэр анхныхаа ургацын дээжийг ч хүртээд авлаа.

Мөн “ӨСӨХ ЗООС” ХХК нь орон нутагтай хамтран ажиллах гэрээнийхээ хүрээнд сумын төвийн засмал зам дагуу “ГЭРЛЭН ДОХИО” хийх гэрээнд гарын үсэг зурлаа. Ингэснээр иргэд аюул осолгүй орчинд зорчиж, замын хөдөлгөөний дүрмээ баримтлан авто тээврийн хэрэгсэл, гэрлэн дохиотой зөв харьцаж сурах нөхцөл бүрдэж байгаа юм.

Гурвантэс сум дахь цагдаагийн тасаг нь ГХУССЗ-тэй хамтран хууль сурталчилах сарын аяныг зохион явуулж байгаа билээ. Уг арга хэмжээний хүрээнд “Ногоон гэрэл цагаан шугам” тэмцээнийг тус сумын ерөнхий боловсролын сургуулийн 5-6, 7-8 дугаар ангиудын нийт 160 гаруй хүүхэд багачуудын дунд зохион явууллаа.

“Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийг дэмжих жил”-ийн хүрээнд Гурвантэс сумын Засаг Даргын Тамгын Газар, Хөдөө аж ахуйн тасгаас санаачлан зохион байгуулж буй “Баялаг бүтээгч

Гурвантэсчүүд" зөвлөгөөн маань эхэллээ. Энэхүү зөвлөгөөнд Тэс нутгийн 60 гаруй бизнес эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид, Нутгийн баялаг бүтээгчид оролцлоо.

Гурвантэс сум дахь Цагдаагийн тасаг болон ГХУССЗ нь "Иргэн ба хууль" хууль сурталчилах сарын аяны хүрээнд Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төв, Соёлын төвтэй хамтран "Хилийн нэг өдөр" нэртэй нэг цэгийн үйлчилгээний арга хэмжээг шивээхүрэн хилийн боомт орчимд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагууд, нүүрс тээврийн жолооч нарт зохион байгууллаа.Тус цагдаагийн тасаг нь гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр цугласан иргэдэд мэдээ мэдээлэл өгч холбогдох хууль тогтоомжуудыг сурталчилан 5 төрлийн 175 тараах материалыг бэлтгэн иргэд олон нийтэд тарааж ажиллаа.

Сумын хэмжээнд салхинцэцэгийн дэгдэлт намдахгүй, нэмэгдэх хандлагатай байгаа тул сумын удирдлагуудын хуралдаанаар дараах шийдвэрүүдийг гаргалаа.

-14 хоногийн хугацаатай олон нийтийн ажлыг хязгаарлах

-Хүн олноор цугларсан газар бага насны хүүхэд авчирахгүй байх

-Оройн цагаар болж буй үзвэр үйлчилгээнд насанд хүрээгүй хүүхдүүдийг оруулахгүй байх

-Сургууль цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн эргүүлд бүх байгууллагууд хуваарын дагуу орой бүр 19-21 цагийн хооронд идэвхитэй оролцох

-Бүх байгууллагууд, сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг 2 ээлжийн амны хаалт зүүж хэвшүүлэх

-Өвдсөн тохиолдол эмчийн заасан зөвөлгөөний дагуу хөл хорио тогтоон магадлагаанд заасан хугацаанд олон нийтийн газраар явахгүй байх гэх мэт олон асуудлыг шийдвэрллээ

2019 оны 11 сарын 30ны өдөр Соёлыг дэмжих жилийн хүрээнд албан байгууллага, ард иргэдийнхээ дунд соёлын идэвхийг дээшлүүлэн урлаг гоо зүйн боловсрол олгох, авъяас чадварыг нь нээн хөгжүүлж хойч үед өвлүүлэн үлдээх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, шинэ авъяастанг илрүүлэх зорилгоор "Урлагийн наадам"-ын үйл ажиллагааг зохион байгууллаа. Урлагийн наадмын тэргүүн байранд Банкуудын хамтарсан багууд Тэргүүн байр.3-р цэцэрлэгийн хамт олон Дэд байр, ЕБСургуулийн хамт олон Гутгаар байр, 28-р цэцэрлэг тусгай байрыг тус тус эзэллээ. Шилдэг номинацийн гоцлол эрэгтэй дуучнаар Хаан банкны ажилтан Т.Лхагва, эмэгтэй дуучнаар 3-р цэцэрлэгийн багш Д., Наранзул, Харилцаа дуугаар ЕБС - ийн багш Х.Амгаланжаргал, Нандин-Эрдэнэ, Гоцлол бүжгээр 3-р цэцэрлэгийн багш Б.Соёлмаа, Гоцлол хөгжмөөр Хаан банкны ажилтан Г.Ганхөлөг, Хамтлаг бүжгээр банкууд, Хамтлаг хөгжмөөр банкууд, Язгуур урлагаар 3- р цэцэрлэг, Жүжигчилсэн сэдвээр банкууд тус тус шалгарлаа.

Байгаль орчин,аялал жуулчлалын яам, Нөхөрлөлүүдийн үндэсний холбооноос 2019 оны 11 дүгээр сарын 29-нөөс 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Мишээл экспо төвд "Экологид ээлтэй бүтээгдэхүүн-2019" 21 аймгийн 254 нөхөрлөл оролцсон үзэсгэлэн худалдааг зрхион байгуулсан. "Энэхүү үзэсгэлэн худалдаанд Гурвантэс сумаас 4-н нөхөрлөл цагаан идээ, тэмээний ноос, гар урлал, сархинагаар хийсэн бүтээлүүдээр оролцож " Алтан нутаг нөхөрлөл 4-р байранд шалгарсан амжилттай оролцсон байна.

Сумын засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзаж "Өглөөний цай" уулзалт арга хэмжээг зохион байгуулж тэдний санал бодлыг сонсож хүлээн авлаа.

2019 оны 12 сарын 14-ны өдөр Уран сийлбэрч Ваанжуурын Уран үйлч Дооцоо нарын нэрэмжит "Үндэсний уран хатгамал"-ын үзэсгэлэн зохион байгуулагдаж уран үйлч эмэгтэйчүүдээ шалгарууллаа. Үүнд: Шилдэг бүтээлээр Ц.Долгор, Тэргүүн бүтээлээр

Н.Бадамханд, Сайхан бүтээлээр Э.Гантуяа /сэврэй сум/, Шагналт бүтээлээр Б.Дэжид нар шалгарлаа.

2019 оны 12 сарын 14-ний өдөр Малчдын урлагийн наадам зохион байгуулсан бөгөөд 150 гаруй малчин эмэгтэйчүүд оролцсон.

2019 оны 12 сарын 15 ны өдөр гурвантэс сумын оюутны нэгдсэн шинэ жилийн арга хэмжээг 12 дугаар сарын 15-ны өдөр 100 гаруй оюутан залуусыг хамруулан өргөн цар хүрээтэйгээр амжилттай зохион байгуулж оны шилдэг оюутнаа тодрууллаа. 2019 оны шилдэг оюутнаар Т.Баяболд, Б.Даш нар тодорсон юм.

Дөрөв: Багт зохион байгуулагдсан ажлууд:

Гоёот багийн өвлийн уламжлалт хурдан тэмээний уралдаан 2019 оны 11 сарын 30, 12 сарын 01-ний өдрүүдэд Гоёот багийн төвд амжилттай зохион байгуулагдсан. Энэ үеэр малчдын дунд үдэшлэгийн арга хэмжээ, Караоке тэмцээнийг зохион байгуулахад Тэргүүн байрыг Гоёот багийн залуу уяач Пүрэвдоржийн Билгүүн, 2-р байрыг Гоёот багийн залуу малчин Сонинхүүгийн Мэндсайхан, 3-р байранд Баясах багийн ХХЭ Нямын Мөнхтогоо, тусгай байрыг Тост багийн ХХЭ Жаргалын Өсөхбаяр нар тус тус эзэлж амжилттай оролцлоо.

2019 оны 12 сарын 01-ний тэмээний уралдаанд Сэврэй, Баяндалай, Ноён, Гурвантэс сумын уяачид оролцож гурван насны 48-н хурдан тэмээ уралдсан. Бүдүүн тэмээний уралдааны тэргүүн байранд Баяндалай сумын уяач Н.Өсөхбаярын шар ат, аман хүзүүнд Гоёот багийн Сумын алдарт уяач Ж.Төмөрбаатарын шар ат, айргийн гуравт Гоёот багийн залуу уяач Бя.Мөнхжаргалын улаан ат, айргийн дөрөвт Нийслэлийн алдарт уяач Н.Мэндбаярын бор ат, айргийн тавд Ноён сумын Сумын алдарт уяач Ж.Отгонбаярын хар ат тус тус хурдалж уясан эзэн унасан хүүхдээ баярлуулсан байна.

Тайлагны уралдааны тэргүүн байранд Бага овоо багийн Сумын тэргүүн уяач У.Түмэнбаярын улаан тайлаг, аман хүзүүнд Гоёот багийн Сумын алдарт уяач Г.Мөнхгэрэлийн улаан тайлаг, айргийн гуравт Гоёот багийн залуу уяач С.Сэнгээгийн ягаан тайлаг, айргийн дөрөвт Бага овоо багийн залуу уяач М.Золбоогийн хар тайлаг, айргийн тавд Гоёот багийн залуу уяач С.Самбуугийн бор тайлаг тус тус хурдалж уясан эзэн унасан хүүхдээ баярлуулсан байна.

Торомны уралдааны тэргүүн байранд Тост багийн залуу уяач М.Хосбаярын халтар тором, аман хүзүүнд Баяндалай сумын уяач Б.Наранмандахын цагаан тором, айргийн гуравт Гоёот багийн залуу уяач С.Самбуугийн шар тором, айргийн дөрөвт Гоёот багийн залуу уяач П.Намсрайгийн хүрэн тором, айргийн тавд Ноён сумын уяач Чойжамцын халтар тором тус тус хурдалж уясан эзэн унасан хүүхдээ баярлуулсан байна.

ДАЛАНЗАДГАД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 4 удаа хуралдаж 12 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Даланзадгад сумын ИТХ-ын ээлжит 08 дугаар Хуралдааныг 2019.12.11-ний өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1.Өмнөговь аймгийн Даланзадгад сум /хот/-ын хөгжлийн хөтөлбөр /2010-2021/-ийн хэрэгжилтийн тухай.

2. Даланзадгад сум/хот/-ыг 2017-2020 онд хөгжүүлэх сумын Засаг даргын үйл ажиллагааны “Амьдрал цэцэглэсэн ногоон Даланзадгад” хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 88.9 хувьтай дүгнэсэн.

3. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт 92 хувьтай дүгнэсэн, 2020 оны үндсэн чиглэлийг баталсан.

4. Сумын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай.

5. Суманд 2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын тайлангийн тухай.

6. Сумын 2019 оны төсөв батлах тухай.

7. Сумын 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай.

8. Сумын нутаг дэвсгэрт 2019 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг батлах тухай.

9. Сум хөгжүүлэх сангийн тайлан, сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлийн ажлын тайлангийн тухай.

10. Сум хөгжүүлэх сангаас нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг шинэчлэн тогтоох тухай.

11. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн тухай.

12. Баг хуваах, баг байгуулах санал хэлэлцэх тухай.

Сумын Засаг даргын А захирамж 41, Тамгын газрын даргын А тушаал 22, Б тушаал 4

2019 оны 12 сард сумын ЗДТГазарт 170 албан бичиг хүлээн авснаас хариутай бичиг 57, сумын Засаг дарга болон Тамгын газраас 98 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаа.

2019 оны 12 сарын байдлаар 30 санал, хүсэлт, өргөдөл ирсэн. 20 өргөдөл гомдлыг шийдвэрлэж хаасан, 6 өргөдөл хугацаандаа явж байна. 70530002 утсанд 3 гомдол мэдээлэл ирснийг холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн хариу мэдэгдэж ажилласан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

2019.11.25-нд Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны үр дүнг танилцуулах уулзалт, семинарт багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан нар хамрагдсан.

2019.11.30 Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан “Эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр”-ийн хүрээнд хийсэн сургалтад багийн Нийгмийн ажилтан, 24 иргэний хамт хамрагдсан.

2019.11.28-29-ний өдрүүдэд “Малын эрүүл мэндийн нэгдсэн системийг нэвтрүүлэх” сургалтад Мал эмнэлгийн улсын байцаагч хамрагдлаа.

2019.12.13-нд аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮДАХ-ээс зохион байгуулсан “Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх нь” сургалтад Боловсрол, соёл хариуцсан бодлогын мэргэжилтэн, Дотоод ажил, хүний нөөц хариуцсан бодлогын мэргэжилтэн нар хамрагдлаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

2019.12.04-нд Аймгийн хэмжээнд сургуулийн сурагчдын нүдний эмгэгийг илрүүлэх, илэрсэн өвчлөл дээр суурилан цаашдын урьдчилан сэргийлэлт, тусламж үйлчилгээний хэрэгцээг тогтоох зорилгоор Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн тэргүүн, сургагч багш, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нүдний эмч нар сургуулийн хүүхдийн “Нүдний эрүүл мэнд” төслийг хэрэгжүүлэхээр Даланзадгад сумын ерөнхий боловсролын 6-н сургуулийг сонгож, төслийн хүрээнд сургуулийн эмч, нийгмийн ажилтанд хараа шалгах аргачлалыг зааж, сонгогдсон сургуулийн хүүхдийг харааны үзлэгт хамруулж, хараа шалгахад шаардлагатай багаж, хэрэгсэл, гарын авлагаар хангах арга хэмжээг зохион байгууллаа.

2019 оны 11 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд “Даланзадгад хотын өдөр”-ийг хотын захирагч Т.Алтансүхийн санаачлагаар анх удаагаа зохион байгууллаа.

“Даланзадгад хотын өдөр”-ийг жил бүрийн тэмдэглэхээр шийдвэрлэсэн бөгөөд энэ удаагийн арга хэмжээг “Ахмад үе”, “Дунд үе”, “Өсвөр залуу үе”-ийн дунд өргөн дэлгэр зохион байгууллаа.

Ахмад үеэ хүндэтгэн “Дуун цэнгүүн”-ийг арга хэмжээг зохион байгуулж Даланзадгад хотын 8 багийн ахмадын үеийн төлөөлөл азай буурлууд маань дуулж, бүжиглэн, урилгаар Улаанбаатар хотоос “Хилийн цэргийн ансамбль”-ийн ахмад уран бүтээлчид оролцлоо.

“Даланзадгад хотын өдөр”-т зориулсан “Хуйрнан шуугигч” хүүхдийн барилдааны өсвөр насны төлөөлөл болох сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 4-5 насны ангилалд

Даланзадгад хотын нийт 10 цэцэрлэгийн шилдэг 32 өсвөрийн бөх барилдсанаас 23 дугаар цэцэрлэгийн М.Тэмүүлэн түрүүлж, 8 дугаар цэцэрлэгийн Т.Бат-эрдэнэ үзүүлсэн.

6-7 насны ангилалд сургуулиудын шилдэг 32 бөх барилдсанаас 5 дугаар сургуулийн Э.Үнэнзориг түрүүлж, Улсын Тэргүүний лаборатори 1 дүгээр сургуулийн Б.Нандинхүү үзүүлсэн амжилт гаргалаа.

“Даланзадгад хотын өдөр”-ийн хүндэтгэлийн арга хэмжээ, баярын хурал, концертыг аймгийн Хөгжимт жүжгийн театрт зохион байгуулж, Даланзадгад хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчит, төрийн чиг үүрэг бүхий нийт байгууллагын шилдэг албан хаагчдад “Даланзадгад хотын өдөр”-ийг тохиолдуулан “Шилдэг төрийн албан хаагч”-ийг шалгаруулж “Батламж”, үнэмлэх, 500000 төгрөгийн шагнал, дэмжлэгийг гардууллаа.

2019.12.13-нд Даланзадгад сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулж 180 иргэн оролцлоо.

Даланзадгад сумын Засаг даргын 2019 оны А/84 дүгээр захирамж, 2019 оны жилийн эцсийн “Мал, тэжээвэр амьтдын улсын тооллого”-ын ажлыг 4 чиглэлд 2019 оны 12 дугаар сарын 07-ноос 12 дугаар сарын 13-ны хооронд зохион байгуулж, дүн мэдээг 12 дугаар сарын 20-ны дотор программд шивж Статистикийн хэлтэст хүргүүлэхээр ажиллаж байна.

“Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил”, “Соёлыг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын малчдын дунд 2019 оны 12 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулсан “Малчдын урлагийн наадам”-д язгуур урлаг, ардын дуу, хөгжим, гоцлол дуу, хос дуу гэсэн 5 төрлөөр оролцож, Язгуур урлагын төрөлд: 1 дүгээр багийн малчин Ч.Шоовдор 2-р байр, Гоцлол дуу төрөлд 1 дүгээр багийн малчин Ц.Өнөрбат 1-р байр, Нэгдсэн дүнгээр 15 сумаас Даланзадгад сум 4 дүгээр байрт тус тус шалгарч амжилттай оролцлоо.

Бог малын хээлтүүлэгчийг нийлүүлгийн бус улиралд эх сүргээс ялган суурилуулах ажлын хүрээнд “Говь гурван сайхан” цэвэр үүлдрийн үржлийн өсвөр 50 ухна нийлүүлэхээр “Монголын мал зүйч үржүүлэгчдийн холбоо”-ны Өмнөговь аймаг дахь салбар нэгжтэй “Үржлийн өсвөр хээлтүүлэгч худалдах, худалдан авах гэрээ” байгууллаа.

2019.12.05-нд 2019 оныг Өмнөговь аймгийн хэмжээнд "Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил" болгон зарлаж энэ ажлын хүрээнд нэлээдгүй хөрөнгө оруулалтыг хийж гүйцэтгэлээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төв Даланзадгад хотноо 200 тонн багтаамж бүхий хүнсний ногооны механикжсан зоорийг байгуулж өнөөдөр албан ёсоор ашиглалтад орууллаа.

11 сарын 10-20-ны өдрүүдэд Зооантропонооз /бруцеллёз/ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх, тандалт шинжилгээний арга хэмжээг зохион байгуулж 8-н багийн 20 өрхийн 700 толгой малыг хамрууллаа.

Даланзадгад сумын Засаг дарга бөгөөд хотын захирагчийн 2019 оны А/64 тоот захирамжийн дагуу нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт 183 байгууллага аж ахуй нэгж орчны 50м газрын хог хаядалыг цэвэрлэж нийт 245 тонн хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүлсэн.

Дөрөв. Багт зохион байгуулагдсан ажлууд

2019.11.22-нд Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар Даланзадгад хотын угтах хаалганы нээлтэд “Ээжүүдийн сүүн өргөл” арга хэмжээнд багийн 15 ээжийг оролцуулан хамтарч ажиллав./8-н баг/

2019.11.22-нд Үндэсний Статистикийн хорооноос зохион байгуулсан “Хяналт шалгалт” -нд 8 баг амжилттай шалгарууллаа.

2019.11.29-нд Шүүхийн Тамгын газраас ирүүлсэн 2020 шүүх хуралдаанд оролцох 187 иргэдийн төлөөлөгчийн тодруулга хийв

2019.12.09-нд “Олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны үр дүнд мэдлэг, ойлголт, хандлагад гарсан өөрчлөлт” судалгаанд 8 багийн 120 иргэн хамрагдлаа.

2019.12.09-нд Хүүхэд, гэр бүл залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан зорилтот бүлгийн хүүхдүүд зориулсан “Хүслийн шинэ жил” арга хэмжээнд 8 багийн 80 хүүхэд оролцлоо.

УИХ-ын гишүүн Л.Энхболдын урилгаар Дундсайхан 4 дүгээр баг, Их-уулын 6 дугаар багийн 90 ахмад Улаанбаатар хот, төрийн ордны чуулганы үйл ажиллагаатай танилцаж, ахмадын “Дуун цэнгээн” арга хэмжээнд оролцлоо.

МАНЛАЙ СУМ

НЭГ. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГААС ГАРСАН БОДЛОГО, ШИЙДВЭР:

Сумын Засаг даргын А захирамж-25 , Б захирамж-2, Тамгын газрын Даргын тушаал-6, ИТХ-ын даргын захирамж-4 , ЭМТ-ийн эрхлэгчээс 5 тушаал нийт 42 захирамж тушаалууд гарсан байна.

ХОЁР. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

Малын эрүүл мэндийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх " нь сэдэвт сургалтанд малын эмч мэргэжилтнүүд нийт 5 хүн хамрагдсан. Тус сургалтын үр дүнд мал эмнэлгийн цахим гэрчилгээ, дуудлага, халдварт болон паразит ариутгал халдваргүйжүүлэлтийн төлөвлөгөөг хэрхэн цахим орчинд оруулж ажиллахыг сурсан.

“Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гэмтлийн үеийн яаралтай болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чадавхижуулах нь” сургалтанд ЭМТ-ийн 4 ажилтан, “Тэмбүүг устгая” аяны үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх, чанаржуулах нь” сургалтанд 2 эмч нийт 6 эмч сувилагч нар хамрагдсан.

ГУРАВ. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

ИТХурал: УИХ-ын даргын ивээл дор жил бүр зохион байгуулагддаг Шатар сонирхогчдын сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж эрэгтэй-12 эмэгтэй-9 нийт 21 хүн, Оюу толгойгоос Улаан загалмайн Хороонд ирсэн гэрүүдийг 4 багийн дарга нарт ирсэн өргөдөл хүсэлтийн дагуу хуваарилж 14 айлд хүлээлгэн өгсөн.

Улаан загалмайн Хорооны гишүүд зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхдэд шинэ жилийн бэлэг гардуулсан. Мөн 9 дүгээр ангийн сурагчид энэ үйл ажиллагааг ИТХ-аас өгсөн удирдамжын дагуу сургууль дээрээ зохиож өөрсдийн хийсэн гар урлалын цүнх болон дэвтэр ном хичээлийн хэрэгслээр бэлэг бэлтгэж зорилтот бүлгийн 6 сурагчдад өгсөн.

Ээлжит 10 дугаар хуралдаан болж тайлан мэдээгээ хэлэлцсэн.

Цэцэрлэг: 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга ашиглалтанд орж нээлтээ хийсэн. Дунд бүлгийн 72 эцэг эхчүүд, 113 хүүхдийн хамт жүжигчилсэн тоглолтыг хийж бусад бүлгийн хүүхдүүд эцэг эхчүүддээ үзүүлсэн. Үүний үр дүнд эцэг эхийн хамтын ажиллагаа батжиж, хүүхдийг танин мэдэх үйл ажиллагаа сайжирсан. Нийт 13 багш ажилчид ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ гаргаж тооцуулж ажилласан.

ЕБСургууль: Миний гэр бүл Миний ертөнц хөтөлбөрт 6-9-р ангийн 130 хүүхэд , “SCHOOL POLICE” үйл ажиллагаанд 1-р ангийн 25 эцэг эх хамрагдав. Соробан сампингийн дэлхийн аваргаас 1 сурагч "АЛТАН ЦОМ" хүртэв.

ЭМТөв: Халдварт саагийн вакцинд-11, УГУ-5, Тавт-11, А гепатит-8 хүүхдэд товлот дархлаажуулалт хийв. Инээмсэглэл- эерэг хандлагыг өөрсдөөсөө эхлүүлье” сэдэвт 21 хоногийн аяныг байгууллагынхаа хүрээнд зохион байгуулж 14 ажилтан хамрагдсан. Хөдөөгийн малчин өрхүүдэд “Ханиад томуугийн үеийн арга хэмжээ, “Түлэгдэлтээс урьдчилан сэргийлье, Хөлдөлт осголтоос сэргийлье сэдвүүдээр мэдээлэл хийж 152 мэдээллийн хуудас тараасан

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 280 малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид даатгуулсан.

Эрүүл Мэндийн Даатгалд 475 малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид даатгуулсан.

Нийгмийн асуудал

“ETERNAL STAR” фитнес клуб /1 дасгалжуулагч 12 хүн хичээллэж байна/ болон “Манлай дэвжээ” албан ёсоор нээлтээ хийж “ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН”-ийг хүүхдүүдийн дунд 3 насны ангилалаар зохион байгуулж нийт 34 хүүхэд барилдсан.

Дотоод ажил, ХШҮ, эрх зүйн мэдээ

Хууль сурталчлах ажлын хүрээнд “Хүүхэд ба хууль” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг 6-9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт 11 хүүхэд ,

Хууль бидний амьдралд аяныг төрийн байгууллагуудын дунд зохион байгуулж 14 хоногийн хугацаатай 12 хуулийг байгууллагууд давхардсан тоогоороо нийт 1300 иргэдэд сурталчилж, дэвжээ тэмцээнд 6 байгууллагын албан хаагчид оролцсон. Үүний үр дүнд иргэд хуулийн талаархи мэдээллээ илүү баталгаажуулж, байгууллагууд ч өөрсдийнхөө хамааралтай хуулиудыг илүү их судалсан.

Нийт 7 тайлан мэдээ хэрэгжилтийг гаргаж албан тоотоор дээд газарт хүргүүлсэн. ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ гаргасан.

ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдаж түлшний хөнгөлөлтөд хамрагдах байнгын асаргаатай 8 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 53 иргэнд 8921150 төгрөг, НМТэтгэмж 50 иргэн 5447980 төгрөг, ХБИргэний хөнгөлөлт 1 иргэн 20000 төгрөг, 200-н Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 10504600 төгрөг, 1 ахмадад Гавьяат цолтон ахмад настанд үзүүлсэн мөнгөн тусламжийн 150000 төгрөг тус тус олголтын жагсаалтыг үүсгэж ХХҮГазарт хүргэсэн. Оюу толгой компаний Дата базын ажил хайгч иргэдийн мэдээллийг шинэчилэн Оюу толгой компаний хүний нөөцөд хүргүүлсэн.

Тав. Багт хийгдсэн ажлууд: Жилийн эцсийн мал тооллого хийгдэж урьдчилсан дүнгээр нийт 220673 мал тоологдлоо.

МАНДАЛ-ОВОО СУМ

Нэг .Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

Сумын ИТХ-н болон Тэргүүлэгчдийн тогтоол 10. /Ээлжит бус хуралдааны тов тогтоох тухай, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны үйл ажиллагааны ажлын тайланд үнэлэлт өгөх тухай, Сумын 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай, Сумын 2020 оны төсөв батлах тухай, 2019 оны Үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 оны үндсэн чиглэл батлах тухай, Сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай, 2020 онд иргэнд өмчлүүлэх газрын байршил хэмжээ батлах тухай. Газрын төлбөрийн итгэлцүүр батлах тухай. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлах тухай, Сумын гамшгаас хамгаалах, эрсдлийг бууруулах төлөвлөгөөг батлах тухай/, Сумын Засаг дарга 12 захирамж гарган, сумын Засаг даргын Тамгын газрын дарга 11 тушаал тус тус гарган ажилласан.

Хоёр. Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 4, албан байгууллагын дарга эрхлэгчдийн хурал цуглааныг 3 удаа зохион байгуулж, цаг үе ийн тулгамдсан асуудлаар ярилцаж шийдвэрлэсэн.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

-Улс тунхагласны баярыг тохиолдуулан “Төрийн албан хаагчдын бахархалын өдөр”-ийг анх удаа архи дарсгүй тэмдэглэж, төрийн албанд олон жил ажилласан, ажил үйлсээрээ тэргүүлж байгаа 6 албан хаагчийг шагнаж, нийт албан хаагчдад хүндэтгэл үзүүлэв.

ХШҮ-ний сургалтад сумын ХШҮ-ний нэгжийн 2 ажилтан хамрагдаж ирсэн ба бодлогын зорилтыг зөв тодорхойлох, Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам сэдвээр дотоодын сургалтыг төрийн албан хаагчид болон байгууллагын дарга, эрхлэгч нарт зохион байгуулав.

Жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын 3Д-н захирамжаар байгуулан ажиллав.

Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих ажлыг зохион байгуулж, 4 төрлийн аминдэмээр хангасан нь тэдний сэтгэл ханамжид нийцсэн үр дүнтэй арга хэмжээ болов.

Аймгийн 3Д-н 1160 дугаар захирамжаар батлагдсан хуваарийн дагуу жилийн эцсийн тайлан мэдээг хүргүүлж байна.

Бүх байгууллагууд ТАХ-н бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланд өөрчлөлт оруулж программд шивэв.

Дархан бэрд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд сумын 4 эмэгтэйг дэмжин оролцуулав.

Говийн дэмжлэг хөтөлбөрийн сүүлийн хагас жилийн урамшуулалыг олгов.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу албан хаагчдад түлшний үнийн хөнгөлөлт олгов.

2019 оны ажил дүгнэх арга хэмжээтэй холбогдуулан шилдэг 5 иргэнийг аймгийн 3Д-н шагналд тодорхойлж, материалыг ТЗУХ-т хүргүүлэв.

Төрийн албан хаагчдын шинэ жилийг байгууллагууд хамтран, архигүй тэмдэглэх талаар байгууллагын удирдлагууд хамтран шийдвэрлэж, хөтөлбөр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

“Архигүй шинэ жил” уриалга гарган цахим хуудас, мэдээллийн самбараар сурталчлан ажиллаж байна.

Цэргийн шинэчилсэн бүртгэлд иргэдийг хамруулах арга хэмжээг 12 сарын 7-оос эхлэн зохион байгуулж, одоо 40 хувийн хамрагдалттай байна.

Бүх байгууллагууд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулж, эд хөрөнгийн зурагтай бүртгэлийг шинээр хийв.

2019.12.01-нд ДОХ-ын өдөрлөг зохион байгуулж 7 байгууллагын нийт 60 албан хаагчид сургалт сурталчилгаа хийн, шинжилгээ авч үйлчлэв. Байгууллагуудын дунд ДОХ-ын эсрэг мэндчилгээний уралдаан зарлан дүгнэв. 43 иргэнд мэдээлэл хийж, тэдний дунд хөгжөөнт тоглоом, бүжгийн тэмцээн явуулав.

Сумын ЭМТ-өөс хүсэлт хүргүүлсний дагуу 12 сарын 05-аас 12-ныг хүртэлх хугацаанд “Хэрмийн цахиур” шүдний эмнэлгийн эмч нар суманд ирж 63 хүнд шүдний эмчиний тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 7 ахмадад хиймэл шүд эрүүл мэндийн даатгалаар хийж, 56 хүнд ломбо, шүд авах, паалан нөхөх эмчилгээ хийсэн нь иргэдэд нэн хэрэгцээтэй тусламж үйлчилгээ боллоо.

Дөрөв: Багт хийгдсэн ажлууд:

Жилийн эцсийн мал тооллогын ажилд 9 ажлын хэсэг 3 багт ажиллаж, 12 сарын 7-17-ны хооронд амжилттай зохион байгуулагдав.

Ажиллах хүчний судалгаанд Өтгөн багийн 10 өрх бүрэн хамрагдав.

Мандал багийн ИНХ-ын хуралдаан зохион байгуулагдаж, 53 иргэн хамрагдан өвөлжилт, отор нүүдэл, багийн 60 жилийн ойн талаар хэлэлцэн шийдвэрлэв.

СЭВРЭЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг дарга 12 захирамж гарган ажилласан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 12 сарын 6-ны өдөр хуралдаж Сумын Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр, Сэврэй сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2019 үндсэн

чиглэлийн хэрэгжилт, 2019 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт, ЗДҮАХ-ийн хэрэгжилтийн явцыг дүгнэсэн.

2019 оны жилийн эцсийн хүн мал, тэжээвэр амьтад тооллогыг 12 сарын 7-ны өдрөөс 12 сарын 17-ны хооронд зохион байгуулж Сумын хэмжээнд 640 өрхийн 2046, Сайншанд баг 318 өрхийн 1036, Хоолт баг 146 өрхийн 441, Бүйлсэн баг 176 өрхийн 568 хүн ам, жилийн эцсийн малын тоогоор тэмээ 6684, адуу 6489, үхэр 1766, хонь 27855, ямаа 147686 тоологдож нийт 190480 толгой мал тоологдсон.

Сумын нийт иргэдийн дунд 11 дүгээр сарын 28-ны өдөр лекц зохион байгуулж цаг үеийн мэдээлэл хийж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авсан. Энэ үеэр сумын эрүүл мэндийн төв 2019 оны үйл ажиллагааны тайлангаа иргэдэд мэдээлсэн.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Аймгийн ХШҮДАХ-ээс зохион байгуулсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх нь” сэдэвт 1 өдрийн сургалтанд хамрагдсан.

ЗДТГ-ын албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах талаар сургалт зохион байгуулсан.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс сумын Засаг даргын Тамгын газрын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж НАХМ-ний хамт шалгуулж сумдаас 2-р байрт шалгарсан.

Засаг даргын Тамгын газрын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж ТЗУХ-д хүргүүлсэн. Биелэлт 91,2%-тай хэрэгжсэн.

Аймгийн Засаг даргын 2017 оны а/1163 дугаар захирамжийн дагуу мэдээ тайланг холбогдох дээд байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Хатан Сэврэйн мэдээ сонины 12 дугаар сарын 1-р нүүрийг бэлтгэж хүргүүлсэн.

2019 оны жилийн эцсийн хүн ам, малын тоонд Сайншанд багийн уулын өвөр хэсэгт 12 сарын 08-12 сарын 11-ний өдрүүдэд Д.Бямбадэлгэр, нийгмийн даатгалын байцаагч Б.Лхагвасүрэн, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн М.Отгонжаргал, ЭМТ-ийн жолооч Э.Гантулга нарын бүрэлдэхүүнтэй баг хүн ам, малын тооны мэдээ судалгаа, элэгний В,С-ийн шинжилгээ авч, Хатан Сэврэйн мэдээ сонингийнхоо сүүлийн дугааруудыг хүргэж, малчдад цаг үеийн мэдээ мэдээлэл өгч, төрийн үйлчилгээний талаар судалгаа авч, өрхийн дэвтэрт хөтөлгөө хийж ажиллалаа.

2019 оны цэргийн тоо бүртгэл 40%-тай хийгдэж байна.

ЕБСургууль: Өмнөговь аймгийн нийт сургуулиудын захирлын Япон улсад туршлага судлах аялал, мөн Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Аюулгүй сургууль сургалтанд сургуулийн захирал Д.Сүхбаатар, Архивчдын сургалт арга хэмжээнд Номын санч-Архив бичиг хэргийн ажилтан Б.Дэлгэрмаа нар, Өмнөговь аймагт тогоочийн сургалтанд туслах тогооч Ө.Сарангарав, Скаутын сургалт арга хэмжээнд 9-р ангийн 5 сурагч 5,Сургалтын менежерүүдийн туршлага судлах уулзалт аялалд Манжуур хот руу Сургалтын менежер Б.Одончимэг нар,Улаанбаатар хотод Жүдо бөхийн тэмцээнд Багш Д.Амгаланбат 2 сурагчийн хамт оролцлоо.

Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Англи хэлний баярт багш Б.Одхүү Б.Лхагвасүрэн нар 17 сурагчийн хамт оролцож жүжигчилсэн тоглолт төрлөөр Тэргүүн байр эзэлсэн байна.

Сурагчдын урлагийн наадам 2019 арга хэмжээг 10 бүлгийн 207 сурагчийг хамруулан 9 төрлөөр зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа.

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого явагдаж нэг бүрчлэн үзэж тооллоо.

Сумын Өмч хамгаалах салбар зөвлөлөөр ашиглалтын хугацаа дууссан боловч ашиглах боломжтой хөрөнгийг ахин үнэлж, ашиглах боломжгүй хөрөнгийг актлуулах хүсэлт гаргаж ажиллалаа.

Цалин урамшууллын төсөв санхүүгийн хүндрэл, 3-р улирлын дүн гарах,шинэ жилийн тоглолт

"Англи хэлний долоо хоног"ийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж Цагаан толгойн баяраа хийсэн 5-р ангийн бяцхан шавь нартаа болон жүжигчилсэн тоглолтоо үзүүлсэн. Мөн сургуулийн багш ажилчдын дунд speaking тэмцээнийг зохион байгуулж 29 багш ажилтан оролцлоо.

Харах өнцөг клубын багш сурагчид улаан загалмай нийгэмлэгтэй хамтран "SANTA CHALLENGE" хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохион байгуулж 6 байгууллага 2 иргэн хамтран ажиллаж 47 бэлэг цугларан 20 өрхийн хүүхэд багачуудыг баярлууллаа.

Төв номын сангийн нүүдлийн уншлагын аянд 4 ангийн 78 сурагч хамрагдлаа.

Түрээсийн сурах бичиг хэвлэгдэн ирж сурагчдад хүргэх үйл ажиллагааг эцэг эх ангийн багш нартай хамтран зохион байгууллаа. Дунд ангийн сурах бичгийн хангалт одоогийн байдлаар 89% тай байна.

Цэцэрлэг: 12 сарыг "Үлгэрч хүүгийн сар" болгон бүх хүүхдийг хамарсан жүжигчилсэн тоглолтыг зохион байгуулж, мөн ном унших чадварын үйл ажиллагааг зохион байгуулж нийт 98 хүүхэд оролцлоо.

Бүтээлч багш шалгаруулах уралдааныг зохион явуулж дүгнэлээ.

Малчдын нийт 69 хүүхдэд даалгавар өгч явуулсан.

Эрүүл мэндийн төв: Дотооддоо 15 ажилтанд /бургуй, шээлгүүр тавих холголт цооролтоос сэргийлэх, Амилуулах суурь тусламж, БЗДХ-аас сэргийлэх сургалтыг 5 удаа хийсэн.

ЭМГ-аас зохион байгуулсан Томуугийн өвчний эмнэл зүй удирдамж сургалтыг 6 мэргэжилтэнд хийсэн байна.

ДОХ-ийн өдрийг "Өөөрчлөлтийг та бид хийнэ" уриан дор тэмдэглэн өдөрлөг зохион байгуулан 56 хүн оролцож сурталчилгаа хийж 2 төрлийн 94 ш-ийг тараасан байна. Мөн витаминжуулсан байна.

Зөв зохистой хооллолт 7 хоног хүрээнд жишиг гал тогоо шалгаруулах удирдамж боловсруулан гал тогоо бүхий 5 байгууллагад өгч шалгаруулсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөгийг тэмдэглэн 19 хүнийг үзлэгт хамруулан АГ, зохистой хооллолт сэдвээр сургалт хийж, гарын бэлэг 19 иргэнд өгсөн байна.

"Тэмбүүг устгая" аяны хүрээнд БЗДХ, гурвалсан халдвараас сэргийлье сургалтыг 74 иргэд хийсэн байна.

Томуу томуу төст өвчний дэгдэлтээс сэргийлэх зөвлөмжийн дагуу ЕБС-ийн 220 хүүхэд багш ажилчид, цэцэрлэгийн 41 эцэг эхэд зөвлөгөө өгч 5 төрлийн гарын авлага боловсруулан 144 ш-ийг тараасан байна.

Жилийн эцсийн мал тооллогоор 3 багийн 5 хэсэгт хөдөөгийн 286 өрхөөр явж эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийж дархлаажуулалтанд 12 хүүхдийг хамруулсан байна.

Соёлын төв: Алтан гадас одонгийн хөшөөний нээлт боллоо.

Улс тунхагласны баярт зориулсан үдэшлэг цэнгүүн уралдаан тэмцээнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

Иргэдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих, бүжгийн спортыг хөгжүүлэн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор нийтийн цэнгээнт бүжгийн сургалтыг 5 хоногийн хугацаатай зохион байгуулан 35 хүн хамрагдлаа.

Хөдөө аж ахуй, үйлдвэржилтийн жил, Соёлыг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулагдсан Малчдын урлагийн наадамд 6 хүн бэлтгэн оролцуулж хос дуу Болд Буджаргал

нар 2-р байр, язгуур урлаг Шатарбат 3-р байр, хөгжим Дамбаренцэн 3-р байрт нийт дүнгээрээ 2-р байрт шалгарсан амжилтыг үзүүллээ.

Сумын аварга шалгаруулах одон бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулан 40 гаруй тамирчин оролцож хурд хүчээ сорьлоо. Эрэгтэй төрөлд Ө.Аюуш эмэгтэй төрөлд Ө.Цэндсүрэн нар тэргүүллээ.

Улс тунхагласны баярт зориулан музей үзүүлэх арга хэмжээг зохион байгуулан геологич Нямдоржийн баярын бичиг, сумын түүхэн ач холбогдол бүхий баярын бичиг дипломоор үзэсгэлэн гаргалаа.

Нийгмийн ажилтан: 12 дугаар сарын лекцэн дээр “Эрх зүйн хөтөч” сургалт мэдээлэл 48 иргэнд хүргэж ажилласан.

12 сард жилийн эцсийн мал тооллогоор “Хамтарсан баг, эрхзүйн хөтөчийн талаарх 100 ширхэг тараах материал хийж өрхүүдэд тараасан.

12 арын сонинд “Эрх зүйн хөтөч” нийтлэл бэлтгэн хэвлүүлнэ.

Аймгийн ЗДТГын ХШҮДАХэлтэсийн шалгалтанд Тамгийн газрын даргатай хамт шалгуулж аймгийн хэмжээнд 2 дугаар байр эзэлсэн.

Жилийн эцэсийн тоогоор Бүйлсэн багийн малын тоо нэгтгэл дээр багийн засаг даргатай хамтран малын тоо, мэдээ тайланг гаргасан.

Жилийн эцсийн тоогоор Сумын төвийн 31 өрхийн ан амын тоог авч, дагавар маягтуудыг авч орон нутагт хийгдсэн болон 202? Онд хийгдэх ажлуудын танилцуулсан.

Аймгийн ГБХЗХГазрын хяналт шалгалтанд бэлтгэж амжилттай шалгагдаж тайлан мэдээг хүргэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөгийг хамтран зохион байгуулсан.

Гар урлалын төвөөр үйлчлүүлэх хүсэлтэй иргэдэд үйлчилгээг үзүүлж бүртгэл хийж харицан ажиллаж байна.

Нийгмийн халамж:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн албанд 5 иргэнийг шинээр бүртгэн төрийн болон хувийн хэвшлийн талаарх ажлын байрны мэдээллийг цуглуулан нийт 48 шинэ ажлын байрны мэдээллийг LMIS нэгдсэн системд бүртгэн ажилласан . Ажил идэвхитэй хайгч 2 иргэнийг ажлын байранд зуучилсан. Төсөл хөтөлбөрт хамрагдсан өрх иргэдтэй уулзан хугацаа хэтэрсэн эргэн төлөлтийг төлүүлэх талаар 2 удаа мэдэгдэх хуудас 4 иргэнд хүргэн 3 иргэн эргэн төлөлтөө бүрэн хийсэн 1 өрх иргэн төлөлтөө хийгээгүй байна.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 27 иргэнд 4.4 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламжийг 23 иргэнд 1,2 сая, жирэмсэн 22 эхэд 0.9 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 95 эхийг хамруулан 4,2 сая төгрөг, нэг удаагийн хөнгөлөлт тусламжинд ХБ 5 иргэнд 1,0 сая төгрөг, Ахмад настан 5 иргэнд 0,6 сая төгрөг, ХБ 4 хүүхдэд 0,5 сая төгрөгний 1 удаагийн хөнгөлөлт тусламжид хамруулан санхүүжилтыг тус тус олгон ажилласан. Мөн хүнс тэжээлийн үйлчилгээнд хамрагдсан 9 өрхийн 51 иргэнд хүнсний 10,11-р сарын талоныг олгон иргэд Түшиг дэлгүүрээр үйлчлүүлсэн. 3 ахмад настанд суултуур 1 ахмадад хөлд оруулагч таяг, тэргэнцэр, 1 ахмадад нурууны бүсийг гэрээт байгууллагатай холбон өгч мэдээлэл зөвөлгөөр ханган ажилласан.

Амьжиргаа дэмжих зөвлөл: Зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдаж Ахмад настны тухай хуулийн 5.1.1-т даасны дагуу 5 ахмад настан, ХБИргэний тухай хуулийн 5,1,3-т заасны дагуу 7 иргэний бичиг баримтыг хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн.

Архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн чиглэлээр: Жирэмсэн 8 эх, цалинтай ээж хөтөлбөрт хамрагдах 10 иргэний хувийн хэргийг шинээр бүрдүүлсэн.

Зорилтот бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрхийг хамгаалах өдрийг "БИД ОРОЛЦЪЁ- ХАМТДАА ХӨГЖЪЕ" уриан дор сум хөдөөгийн 48 иргэнд урилга хүргэн 25 иргэн 6 хүүхэд оролцон эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, арга зүйн зөвлөгөө, сургалт хичээл, АХА танин мэдэхүйн асуулт хариултын тэмцээн шинэ жилийн арга хэмжээ зохион байгууллаа. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөрийг дэмжих, тэдний нийгмийн амьдралд хөл алдах, өөрсдөө яаж хөгжиж болох талаар ярилцаж тодорхой шийдэлд хүрлээ. Өөртөө итгэх итгэлд нь бага ч болов сэдэл ухаарал дэм өгөх зорилгоор жүжигчин Баясгалангийн амьдрал тэмцэл ялалт харуулсан video үзүүлж харилцан ярилцаж мөн Ник Вуйчичийн илтгэлийг хамтдаа

үзэн.Бидний гарц БЭ РХШЭЭЛ-БОЛОМЖ-АМЖИЛТ нэртэй явагдан сумын удирдлагууд оролцсон.

Төсөв санхүү:

Төсөвт болон орон нутгийн өмчит байгууллагуудын үлдэх өртөг нь 0 сэн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь дахин үнэлэх, ашиглахгүй байгаа хөрөнгүүдийг актлах ажлыг зохион байгуулж нийт 201 төрлийн 375 ширхэг 239169877,15 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэхээр явуулсан ба 177 төрлийн 114973153,27 төгрөгийн үнэ бүхий 957 ширхэг хөрөнгийг актлахаар ИТХ-д оруулахаар бэлдэж байна.

Сумын ИТХурлыг хийлгэж 2019 оны төсөвт өөрчлөлт оруулж байгууллагуудын өр авлагыг зохицуулан ажилласан ба ЕБС-ын төсөв хүрэхгүй байгаа тул НДШ-ын зардалд өртэй гарахраар болоод байна

Байгууллагуудын өр авлага талаар: ИТХ - Цалингийн зардал 552,9 бусад зардал 175 мян.төгрөгийн ЗДТГ- Цалингийн зардал 2318,5 Шуудан холбооны зардал 1701,3 мян.төгрөгийн Соёлын төв- Цалингийн зардал 4,3 мян.төгрөгийн ЕБСургууль- Цалингийн зардал 4940,7 НДШ зардал 21728,8 мян.төгрөгийн Цэцэрлэг- Түлш халаалтын зардал 5775,2, цэвэр ус 72,4 бичиг хэргийн зардал 70,0мян.төгрөгийн, ЭМТөв- Цалин хөлс 871,8 Цэвэр бохир ус 278,8 Эм бэлдмэл 2584,2 хоол 731,1 тээвэр шатахууны зардал 1675,8 мян.төгрөгийн тус тус өртэй байна.

Орон нутгийн төсвийн орлогоор нийт 57,6 сая төгрөг, санхүүгийн дэмжлэг 414,7 сая төгрөгийг авч нийт орон нутгийн төсөвт байгууллагууд болон УТБайгууллагуудын тогтмол зардалаад нийт 505,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан байна

Орон нутгийн болон ТЗШ-ийн байгууллагууд төсвийн гүйцэтгэлийн гүйлгээнүүд хийгдэж байгаа.

Хөдөө аж ахуй:

Малын эмч, мэргэжилтэнгүүдийг чадавхижуулах, шинэ техник, технологид суралцуулах зорилгоор Улсын Мал эмнэлгийн ерөнхий газар, Ногоон алт төслийн санхүүжилтээр "Малын эрүүл мэндийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх " нь сэдэвт сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 28, 29 -ний өдрүүдэд аймгийн Мал эмнэлгийн газар дээр зохион байгуулж байна. Уг сургалтад 15 сумын Мал эмнэлгийн тасаг, 34 хувийн мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн 55 малын эмч, мэргэжилтэнгүүд хамрагдаж, мэдлэг мэдээллээ дээшлүүлж ажилсан.

Мал эмнэлгийн гарал үүсэлийн гэрчилгээ 250 ш гэрчилгээг өмнөговь аймгийн мал эмнэлгийн газарт тушаасан.

2019 оны жилийн эцсийн хүн ам, малын тоонд Сайншанд багийн уулын өвөр хэсэгт 12 сарын 08 12 сарын 11-ний өдрүүдэд Д.Бямбадэлгэр, нийгмийн даатгалын байцаагч Б.Лхагвасүрэн, Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн М.Отгонжаргал, ЭМТ-ийн жолооч Э.Гантулга нарын бүрэлдэхүүнтэй баг хүн ам, малын тооны мэдээ судалгаа, элэгний В,С-ийн шинжилгээ авч, Хатан Сэврэйн мэдээ сонингийнхоо сүүлийн дугааруудыг хүргэж, малчдад цаг үеийн мэдээ мэдээлэл өгч, төрийн үйлчилгээний талаар судалгаа авч,өрхийн дэвтэрт хөтөлгөө хийж ажиллалаа .

12 сарын 2 нд Сэврэй гурван мөнх мал эмнэлэг айлд өрхөд байгаа малын эмийн үлдэгдэл хяналт тавиж ажилсан.

Алаг цавын нуруу, Сэврэй гурван мөнх, Мал эмнэлгийн гэрчилгээ мах сүү арьс ширэнд 116 ш бичсэн.

Хөдөө аж ахуйн тагсийн дарга П.Отгон Улаанбаатар хотод Мал зүйчдын зөвлөгөөнд оролцож байна.

ХАА-н тасгийн мэргэжилтэн Э.Чулуунцэцэг 12-р сарын 5-нд Өмнөговь аймагт болсон Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлт тооцох аргачлал сургалтанд хамрагдсан.

Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн баярын арга хэмжээнд Хоолт багийн ногоочин Б.Алимаа, Бүйлсэн багийн ногоочин А.Долгор нарын хамт оролцсон.

12-р сарын 6-ны өдөр Ногоон эдийн засаг Өмнөговь аймгийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санаачлага форум 2019 арга хэмжээнд оролцсон.

ХАА, үйлдвэржилтийг дэмжих дэд хөтөлбөрийг ИТХ-н тэргүүлэгчдийн хуралд тайлагнаж 68%-тай дүгнүүлсэн.

2019 шинээр гарсан 2 худгыг хүлээж авсан.

Худаг эзэмшлийн журмын хэрэгжилтийг ИТХ-д танилцуулж дүгнүүлсэн. 2019 оны жилийн эцсийн тоогоор хөдөөгийн худаг эзэсшигч өрхүүдээс санал хүсэлт судалгаа авсан.

Говийн оюу хөгжлийг дэмжих сан, Хүнс хөдөө аж ахуйн газар хамтран хэрэгжүүлсэн Оюу хүлэмж 2 төсөлд 5 өрхийг хамруулж 50 %-н хөнгөлөлттэй үнээр хүлэмж олгосон.

2019 оны хүн амын тоонд явж 25 өрхөөр орж цаг үеийн мэдээллийг хүргэж, холбогдох судалгаа мэдээлэл авсан.

ХАА-н тасгийн хяналтанд байгаа Засгийн газрын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг гаргаж Е оффис программд оруулсан.

2019 оны үндсэн чиглэл, Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний ХАА-н тасагтай холбоотой заалтуудын хэрэгжилтийг гаргаж Е оффис программд оруулсан.

Байгаль орчин аялал жуулчлал газрын харилцааны чиглэлээр

Байгаль орчны статистикийн БОХ тайлан, жилийн ажлын тайланг гаргаж файлаар болон цаасаар хүргүүлсэн.

Сумын ИТХурлын тэргүүлэгчдийн хурлаар сумын дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тайлагнаж, 2019 оны өссөн дүнгээр “Ногоон сум” дэд хөтөлбөрийг 87,9 хувь, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг 58,55 хувьтай дүгнүүлсэн

Улсын бүтгэгч: Улсын бүртгэлийн хэлтсийн Нэг цэгийн үйлчилгээ тус суманд 2019 оны 11 сарын 30-ны өдөр ажиллаж дараах үйлчилгээ үзүүллээ.

Гадаад паспортын захиалга 30, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэл 2, хуулбар лавлагааны өргөдөл 1 шийдвэрлэж, иргэний үнэмлэх сунгалтын хугацаа хэтэрсэн 1 иргэнийг торгуулиас чөлөөлж бүртгэсэн байна.

12 сарын 19-ний байдлаар өссөн дүнгээр иргэний гэр бүлийн байдлын төрсний бүртгэлд 42 хүүхэд

-Гэрлэлтийн бүртгэлд 3 хос

-Нас барсны бүртгэлд 18 хүн

-Эцэг тогтоолтын бүртгэлд 11

-Шилжин ирсэн 63 иргэн

-Баг хоорондын шилжилт хөдөлгөөнөөр 14 иргэн

-Иргэний шинэчилсэн бүртгэлд 58 иргэн

-Иргэний үнэмлэх үрэгдүүлж захиалсан 14 иргэн

-Цахим үнэмлэх 103 иргэнд

-Дахин олголтын гэрчилгээ 4 иргэн

-Лавлагаа 19 иргэнд захиалж олгосон

-Гадаад паспорт 75 иргэн тус тус захиалсан байна

-Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлд 5-н иргэн бүртгэж гэрчилгээг олгосон.

Газрын харилцааны чиглэлээр: 11-р сарын 15- 12 сарын 5-г хүртэл ГХБХБГазарт 2019 оны жилийн эцсийн талайн тушаах ажлаар ажилласан.

2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг 78,8 хувьтай дүгнүүлэн, 2020 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Иргэдийн төлөөлөгчдын хурлаар 12-р сарын 06 ны өдрийн 11/08 тогтоолоор батлуулсан.

2020 оны Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршлыг 10 иргэнд 7,5 га газрыг өмчлүүлхээр 11/09 тогтооллоор батлуулсан.

Газар эзэмших эрхийн аж ахуйн нэгж байгууллагийн 2 гэрчилгээ шинэчлэн гарган гэрээ байгуулсан.

Газар эзэмшигч 3 иргэний өргөдөл хүлээн авсан. Өргөдлийг Багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлнэ.

ХАНХОНГОР СУМ

Нэг.Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

Сумын засаг даргын 12 захирамж гарсан. Үүнээс гэрээ байгуулах тухай -3, ажлын урамшуулал олгох-3, хөрөнгө зарцуулах тухай-4, ажлын хэсэг байгуулах-2, Засаг даргын тамгын газрын даргын тушаал 8 гарсан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт: Сумын ИТХ-аас иргэдийн нийтийн лекцийг 2 удаа зохион байгуулсан. Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн яам, Боловсрол соёл,шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан хяналт шалгалтанд байгууллагын

дарга эрхлэгч, статистик хариуцсан мэргэжилтнүүд хамрагдаж мэргэжил арга зүйн зөвлөмж зөвлөгөөг хүлээн авч ажиллалаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12, 13 дугаар хурлыг зохион байгууллаа.

